

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр Цаг: 18:00 -20:20

Хурлын хэлбэр: Цахимаар

Хурлын дарга: Ломбын Эрхэмбаяр

Хурлын нарийн бичгийн дарга: Дашцэрэнгийн Наранцэцэг

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо:153

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо: 163,716,903 ширхэг.

Хурлын ирц: 81,86%

Тусгай тэмдэглэл:

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “Түмэн шувуут” Хувьцаат компанийн цахим хуудсаар дамжуулан шууд хийх болсон тухай танилцуулав. Мөн хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

- 1 дэх асуудал:** “Түмэн шувуут” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;
- 2 дахь асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- 3 дахь асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 4 дэх асуудал:** Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулах тухай;
- 5 дахь асуудал:** Мэдээлэл өгөх

ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

1 дэх асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. Компаний 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

Тусгай тэмдэглэл:

Хувьцаа эзэмшигч: Аудитын шалгалтаар ямар нэгэн зөрчил дутагдал илэрсэн үү?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Гранд торнтон аудитын компани “Түмэн шувуут” ХК-ний санхүүгийн тайлан, “Усжуулах” ХК-ийн санхүүгийн тайлан болон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан. Ямар нэгэн томоохон зөрчил дутагдал бол гараагүй. Цаашид нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагааг илүү сайжруулахын тулд авч хэрэгжүүлэхэд зохистой үнэтэй заавар, зөвлөмжийг бидэнд өгсөн.

Хувьцаа эзэмшигч: Корона вирус танай компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Корона вирус зөвхөн манай компанид бус дэлхийн эдийн засагт бүхэлд нь нөлөөлж байна. Хүнсний салбарын хувьд одоогийн байдлаар хүчтэй нлөө үзүүлээгүй байна. Гэхдээ манай харилцагч нарт нөлөөлөөд эхэлсэн байна. Сургууль цэцэрлэг амарсан зэрэг нь дам бидэнд бас нөлөөлж байна. ЭМЯ болон ХӨСҮТ-с өгч байгаа заавар зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа хэвийн явуулахын тулд нарийн чанд төлөвлөн ажилчидаа нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, бээлийн, амны хаалтаар ханган компанийхаа хэмжээнд ажилчидаа хамгаалж байна.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
163,347,826	100%	0	0%	0	0%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрөв.

2 дахь асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь : Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээллийг танилцуулж хэлэлцэв.

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн цахимаар хэрхэн саналаа өгөх зөвлөмжийг өгөв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр
- 1.1.2. Балай овогтой Тунгалаг
- 1.1.3. Жигжид овогтой Болд
- 1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
- 1.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү
- 1.1.6. Цэрэннадмид овогтой Рэнчинсэнгээ

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал
- 1.2.2. Агипар овогтой Бакей
- 1.2.3. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ

- 2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгов.
- 3. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.
- 4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-д үүрэг болгов.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
163,344,326	99,99%	0	0%	3,500	0,01%

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Ломбо Эрхэмбаяр	171,099,976	17,46%
Балай Тунгалаг	171,017,286	17,45%
Жигжид Болд	160,142,453	16,34%
Эрхэмбаяр Баяржаргал	160,442,361	16,37%
Эрдэнэчулуун Жаргалхүү	158,672,106	16,19%
Цэрэннадмид Рэнчинсэнгээ	158,712,774	16,19%

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, Э.Жаргалхүү, Ц.Рэнчинсэнгээ нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Цэдэв Наран-Учрал	161,788,900	33,02%
Цэгмэд Лут-Очир	7,254,067	1,48%
Агипар Бакей	162,133,768	33,09%
Гочоо Мөнх-Эрдэнэ	158,866,743	32,42%

Үүнээс Ц.Наран-Учрал, А.Бакей, Г.Мөнх-Эрдэнэ нар сонгогдов.

3 дахь асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай хэлэлцэв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлав. (*Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалинг хуралд оролцсон байдлаар тооцох ба ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 500,000 төгрөгийн цалин авахаар батлав.*)
2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
163,313,326	99,98%	2,000	0,01%	32,500	0,01%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,98% нь зөвшөөрч, 0,01% нь татгалзаж, 0,01% нь түдгэлзэв.

4 дэх асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга: Л.Эрхэмбаяр

“Түмэн шувуут” Хувьцаат компани нь IPO гаргахдаа Махны чиглэлийн тахианы аж ахуй байгуулах төсөл хэрэгжүүлэхийн тулд 3,9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Энэхүү махны чиглэлийн тахианы аж ахуйг Их булагт байгуулахаар шийдвэрлэн шувууны 2 байр барьж ашиглалтад оруулахад бэлэн болоод байна. Гэвч цаг үеийн нөхцөл байдлаас болон дараах

үндэслэлүүдээс болж махны чиглэлийн тахианы аж ахуй байгуулахад хүндрэлтэй байдал үүсээд байна. Үүнд:

1. ОХУ, БНХАУ-д махны чиглэлийн тахианы аж ахуйд шувууны ханиад дэгдсэн.
2. Шувууны ханиад гарсан бүс нутгаас үржлийн өндөг 3 жилийн хугацаанд импортлох боломжгүй байдаг.
3. Махны чиглэлийн тахианы үржлийн өндөгний үнэ 75%-иар нэмэгдсэн.
4. Covid-19 гарсантай холбоотой хурдан хугацаанд олон удаа үржлийн өндөг импортлох боломж хаагдаж байгаа зэрэг болно.

Тусгай тэмдэглэл:

Хувьцаа эзэмшигч: Махны чиглэлийн тахианы аж ахуй байгуулахад зориулах 3,9 тэрбум төгрөгийг өндөглөгч тахианы аж ахуй байгуулахад зарцуулна гэсэн үг үү?

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Тийм ээ, Та маш зөв ойлгосон байна.

Хувьцаа эзэмшигч: Цаг үеийн байдал сайжрахад махны тахиа болгож болох уу?

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Нэгэнт өндөглөгч тахианы тоног төхөөрөмж суулгасан бол боломжгүй байдаг юм.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн үнэт цаасны танилцуулгын 71-73 дугаар хуудсанд тусгасан шинээр байгуулагдах махны чиглэлийн тахианы аж ахуйн чиглэлийг өндөглөгч тахианы аж ахуй болгон өөрчлөхийг батлав.
2. Махны чиглэлийн тахианы аж ахуйг шинээр байгуулахад зориулан төсөвлөсөн 3,9 тэрбум төгрөгийг өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөн байгуулахад зарцуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д зөвшөөрөв.
3. Хөрөнгийн зарцуулалтын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байхыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгов.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
163,316,009	99,98%	22,317	0,01%	9,500	0.01%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,98% нь зөвшөөрч, 0,01% нь татгалзаж, 0,01% нь түдгэлзэв.

5 дахь асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: “Түмэн шувуут” Хувьцаат компанийн цаашид хийхээр төлөвлөж буй стратегийн зорилтот ажил болох эрдэнэ шиш тариалах, хонины мах экспортлох бэлтгэл ажлуудын судалгаа, туршилтын талаар мэдээлж, 100% Органик компост бордоо үйлдвэрлэн Органик хүнсний тухай хуулийн дагуу шийгмийн хариуцлагын хүрээнд идэвхитэй оролцон ажиллахаа мэдэгдлээ. Мөн түүнчлэн Түмэн шувуут ХК-ийн савлагаатай өндөгийг худалдан авсан хүн бүр хувьцаа эзэмшигч болох боломжтой болох юм. Учир нь Хувьтай Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр савлагаатай өндөг худалдан авсан өндөгний тоогоор өндөг бүрт 7-10 төгрөгийн хувьцааны урамшуулал авч олгоно. “Түмэн шувуут” ХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс шийдвэрлэсэн “Ногдол ашгийн тухай” тогтоолыг танилцуулав. “Түмэн шувуут” Хувьцаат компани нь 2019 оны цэвэр ашгийн 30 хувийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилна гэж шийдвэрлэсний дагуу нийт 969 сая төгрөг хуваарилах ба нэгж хувьцаанд 4,8 төгрөг ногдоно. Ногдол ашгийг 2020 оны 06 сарын 24-ний өдрөөс эхлэн тарааж эхлэх бөгөөд бүртгэлийн өдөр нь 2020 оны 04 сарын 07-ний өдөр юм.

Тусгай тэмдэглэл:

Хувьцаа эзэмшигч: Ногдол ашгаа хэрхэн авах вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Та ногдол ашгаа Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан авах боломжтой.

Хувьцаа эзэмшигч: Хувьцааны үнэ унаа байгаа шалтгаан юу вэ?


Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Энэ тал дээр бидний хувьд мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авсан. Өнгөрсөн жилийнхээс цэвэр ашиг нь 23 хувиар өсөөд үйл ажиллагаа нь хэвийн байхад хувьцааны ханш унаад байгаа нь манай үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр унаад байна. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдалтай, ялангуяа сүүлийн үед корона вирустэй холбоотой байна. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй ТӨП-20 аж ахуйн нэгжийн хувьцаа ч мөн 20-иос дээш хувиар унасан. Бидний хувьд үйл ажиллагаа хэвийн явж байна. Өнгөрсөн жилээс үйлдвэрлэл болон ашгийн хэмжээ нэмэгдсэн. Хувьцаа бол цаашид өснө гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Гүйцэтгэх захирал Ж.Болд: IPO гаргасны дараагаар богино хугацаанд хувьцаагаар тоглогч нар их орж ирсэн. Тэд хувьцаа өссөн үед зарна гэсэн төлөвлөгөөтэй байдаг. Жижиг тоглогч нар хувьцааны үнийг савлуулаад байгаагаар бас холбоотой.

2. Энэ асуудлаар ямар нэгэн шийдвэр гараагүй бөгөөд санал хураагаагүй болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 20:20 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:  Л.ЭРХЭМБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Д.НАРАНЦЭЦЭГ